



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/145

Хэрлэн сум

Санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.1-ийн "а", 29.1.6-ын "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1. дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 9 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Архидалтгүй Хэнтий" дэд хөтөлбөрийн хүрээнд "Хэрлэнгийн цэнхэр алс" ТББ-тай хамтран ажиллах, сайн дураараа архины хамаарлаас гаргахыг хүссэн иргэдэд танин мэдэхүйн мэдлэг олгох, архины хамаарлаас гарсан иргэдийг давтан сургалтад хамруулах, урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулах, хамтын нөхөрлөл байгуулж ажилтай орлоготой болоход нь санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Санхүүгийн дэмжлэгт шаардагдах 3000000 /гурван сая/ төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн "Архидалтгүй Хэнтий" дэд хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваад/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА